



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/321

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 46 дугаар дүгнэлтийн дагуу ӨВАОНӨГ/202304053/01/01 урилгын дугаартай Өвөрхангай аймгийн "Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх" зорилтот жилийн хүрээнд Арвайхээр суманд байгуулах хүлэмжийн цогцолборын хашаа барих ажлыг 70,000,000 (далан сая) төгрөгөөр Баянговь-Ус ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

5223 11 0616

D:My Doc. Zahiramj. Zasag darga